| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,550,080.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,187,907.00 | 2,493,700.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь " Сургалтын таатай орчин бүрдүүлсэн, чадвартай хөгжсөн багш ажилтантай, чанартай хүртээмжтэй сургалттай, стандартын шаардлагыг жигд хангасан, хүүхдэд ээлтэй сургууль болно" гэсэн эрхэм зорилго доор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022-2023 оны хичээлийн жилд өдрөөр 408 хүүхэд, 100 хүүхдийн хүчин чадалтай дотуур байранд 95 хүүхэд, 1-5 дугаар ангийн 189 хүүхэд үдийн цай хөтөлбөрт хамрагдсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор гарсан Засгийн газрын "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах" тухай 91, 2022.06.29-ны өдрийн "Журамд өөрчлөлт оруулах тухай" 252-р тогтоол, салбарын сайдын "Заавар батлах тухай" 2022.05.12-ны өдрийн А/170, "Журам шинэчлэн батлах тухай" 2022.11.14-ны өдрийн А/465, "Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай" 2022.04.01-ний өдрийн А/122 "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам" 2022.10.26-ны өдрийн А/430, БШУС, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Багшийн эрүүл мэндийн талаар авах

арга хэмжээний тухай" 2022.06.29-ны өдрийн А/238, А/340 зэрэг тушаал шийдвэрүүд шинээр батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн БШУЯ-ны дотоод аудит хэрэгжүүлдэг бөгөөд тус сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод төсвийн шинэчлэлтэй холбоотой хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэхгүй мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлээр бүртгэлд тусган тайлагнасан байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,177,639.1 мянган төгрөг болж өмнөх оноос 595,997.0 мянган төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 96,415.40 | 96,415.40 |
| Авлага | 24,627.70 | 2,327.70 | -22,300.00 |
| Урьдчилгаа тооцооны авлага | 0.00 | 5,150.00 | 5,150.00 |
| Бараа материал | 114,872.60 | 113,289.20 | -1,583.40 |
| Үндсэн хөрөнгө | 1,900,425.10 | 2,497,620.70 | 597,195.60 |
| Хуримтлагдсан элэгдэл | -458,283.40 | -537,164.20 | -78,880.80 |
| **Нийт хөрөнгө** | **1,581,642.10** | **2,177,639.10** | **595,997.00** |
| Өр төлбөр | 0 | 90.00 | 90.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 364,824.40 | 364,824.40 | 0.00 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,581,642.10** | **2,177,639.10** | **595,997.00** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 96,415.4 мянган төгрөг болж өссөн нь төсвийн шинэчлэлтэй холбоотой хэмээгдсэн зардлыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхгүй мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнадаг болсонтой холбоотой ба цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 37,762.1 мянга, ажил олгогчийн НДШ-ын зардалд 8,361.1 мянга, хүүхдийн хоолны зардалд 10,611.9 мянган төгрөгийн хэмнэлт тус тус үүссэн байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 22,300.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд авлагаар тусгасан хөрөнгийг хүлээн авч орлогоор бүртгэн авлага хаасантай холбоотой байна.

Урьдчилгаа тооцооны авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 5,150.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд ажилтан албан хаагчид цалингийн урьдчилгааг олгоод суутган тооцоогүй байсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 113,289.2 мянган төгрөг болж өмнөх оноос 1,583.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 115,368.4 мянга, 12,034.1 мянган төгрөгийн өмнөх оны авлагаар тусгасан байсан материалыг орлогоор бүртгэсэн, 107,826.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Үүнээс тусгай зориулалтын материал 3,296.0 мянга, бусад хангамжийн материал 1,730.4 мянган төгрөгөөр өссөн голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,497,620.7 мянган төгрөг болж өмнөх оноос 597,195.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн шинэчлэлтэй холбоотой нөхөн хангалтын зардлын санхүүжилтээр ерөнхий гэрээний дагуу худалдан авсан 23,374.0 мянган төгрөгийн цахим танхимын таблет, төсвийн хөрөнгөөр худалдан авсан, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 2,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дотуур байрны хүүхдийн засварт 513,581.6 мянган төгрөгийн урсгал засвар хийгдсэнийг барилга байгууламжийн дансанд сайжруулалтаар бүртгэсэн, АЗДТГ-аас 48,930.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эхэнд өр төлбөр байхгүй байсан бөгөөд тайлант хугацаанд 90.0 мянган төгрөг болж өссөн нь хувь хүнд төлөх өглөгтэй холбоотой бөгөөд төрийн сан гүйлгээг хийхдээ 100,0 мянган төгрөгийн шилжүүлгийг 10,0 мянган төгрөгөөр андууран хийсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 924,754.6 мянга төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 99,156.1 мянган төгрөгөөр бууруулж 825,598.5 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 931,638.4 мянган төгрөг болгож 106,039.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь төсвийн шинэчлэлтэй холбоотой сургуулийн суралцагчдын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байгаатай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81801, 81806, 81816, 81823, 81834, 81835, 81848, 81844, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,032,569.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 931,638.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 100,931.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 931,638.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 100,931.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвөөс 927,386.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 128,870.3 мянган төгрөгийг зарцуулж 10,531.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн болно.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 962,887.8 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг 96,415.4 мянган төгрөгөөр орон нутгийн урсгал зардлыг 10,531.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| Д/д | Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 80111 | Нийтлэг үйлчилгээ | 139,402.00 | 128,870.30 | 10,531.70 | 92.45 |
| 2 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 2,860.20 | 2,835.70 | 24.50 | 99.1 |
| 3 | 80312 | Сургалт семинар | 1,430.10 | 1,400.00 | 30.10 | 97.9 |
| 4 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих зардал | 3,289.30 | 3,255.00 | 34.30 | 99.0 |
| 5 | 81801 | Үдийн цай хөтөлбөр | 42,528.00 | 40,357.90 | 2,170.10 | 94.9 |
| 6 | 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 63,114.90 | 49,516.80 | 13,598.10 | 78.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 29,970.00 | 23,374.00 | 6,596.00 | 78.0 |
| 8 | 81823 | Боловсролын байгууллагын багш, | 6,435.50 | 5,720.10 | 715.40 | 88.9 |
| 9 | 81834 | Боловсролын стандарт, сургалтын зардал | 707,881.30 | 649,065.00 | 58,816.30 | 91.7 |
| 10 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 69,877.30 | 56,189.30 | 13,688.00 | 80.4 |
| 11 | 81848 | Сурах бичгийн түрээсийн | 1,757.60 | 1,037.60 | 720.00 | 59.0 |
| 12 | 83602 | ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан /нэмэлтийн татсан мөнгө/ | 2,493.90 | 2,136.50 | 357.40 | 85.7 |
| | | **Нийт** | 1,071,040.10 | 963,758.20 | 107,281.90 | 89.98 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030315401 тоот дансаар 2022 оны байдлаар гүйлгээ гараагүй байсан бөгөөд өмнөх оны үлдэгдэл 2,493.9 мянган төгрөгийг үндсэн дансанд төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* *Ӏмян.төгрөгөөр/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Өмнөх оны үлдэгдэл | 2,493.70 |
| | **Нийт орлогын дүн** | 2,493.70 |
| 1 | УТ-ын дансанд төвлөрүүлсэн | 2,493.70 |
| | **Нийт зарлагын дүн** | 2,493.70 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзэням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугээр сарын 21-ны өдрийн 172 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Оюунтуяа нар зурж байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,053,938.3 мянган төгрөгөөс 15,809.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 11,066.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл*

| Д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлбэл зохих/ удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Мэдээлэл байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 3 | 3 | 2 | 3 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 2 | 2 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 0 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 20 | 16 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 36 | 60 | 0 | 0 |
| | **Нийт** | **27** | **151** | **61** | **85** | **2** | **3** |

*Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн систем*

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсвийг улирал бүр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүтэн жилээр мэдээлэх 825696.7 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, 699459.6 мянган төгрөгийн 85 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 175,909.3 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 27,383.4 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын, 148,525.8 мянган төгрөгийн нийцлийн аудитын алдаа зөрчил илэрснээс 1,036.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 174,872.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 8 заалт бүхий зөвлөмжийг хүргүүллээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022.05.27-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,036.4 | 1 | 1,036.4 | 100 |
| Албан шаардлага | 1 | 6,378.8 | 1 | 6,378.8 | 100 |
| Зөвлөмж | 7 | 19,968.2 | 7 | 19,968.2 | 100 |
| **Нийт дүн** | **9** | **27,383.4** | **9** | **27,383.4** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар дотуур байрны хоолны зардал 10,611.9 мянга, Үдийн цай хөтөлбөрийн зардал 2,170.4 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,292.1 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 6,099.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, нийцлийн аудит буюу шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага, 2,192.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлэв.

### 5.1 Залруулга

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 32,584.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардалд биет ба бие бус хөрөнгө худалдан авсан зардалд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 6.1 "Тайлангийн хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд үзүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд 32,584.0 мянган төгрөгийг зардал хооронд залруулав.

### 5.2 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд хугацаанд 27,900.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг олгосон бөгөөд 1-р сард 8,000.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган авсан боловч нэмж олгосон цалин гэж ажилчдын гарт олгох цалинд нэмж өгсөн боловч цалингийн урьдчилгааг суутгахдаа 7-н ажилтнаас 5,699.4 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг дутуу суутгаж, 2 ажилтнаас 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг илүү суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх; 16 дугаар зүйлийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Тохиолдсон байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 5.3 Албан шаардлага

*<u>Илрүүлэлт:</u>* Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсвийг улирал бүр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүтэн жилээр мэдээлэх 825696.7 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, 699459.6 мянган төгрөгийн 85 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Илрүүлэлт:*** 1. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 1,163.5 мянган төгрөгийг хүүхдийн үдийн цайны зардалд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Засгийн газрын 2022 оны "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах" тухай 91 тогтоолыг тус тус зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж***: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангаж ажиллах зөвлөмж өгөв.

2. Тайлант хугацаанд 1,029.2 мянган төгрөгийн шатахууны орлого зарлагын нягтлан бодогч хийсэн боловч нярвын тайлан гаргаж ирүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалтыг зөрчсөн нь "Тохиолдсон байх", "Тасалбар болголт" "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Цаашид тайлант хугацаанд багтаан нярвын тайланг гангаргуулан баталгаажуулан анхан шатны баримт материалд үндэслэн санхүүгийн тайланд тусган ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайлант хугацаанд хугацаанд 27,900.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг олгосон бөгөөд 1-р сард 8,000.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган авсан боловч нэмж олгосон цалин гэж ажилчдын гарт олгох цалинд нэмж өгсөн боловч цалингийн урьдчилгааг суутгахдаа 7-н ажилтнаас 5,699.4 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг дутуу суутгаж, 2 ажилтнаас 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг илүү суутгасан байна. | 1 | 6,099.4 | 1 | 6,099.4 | | | | | | | | |
| 2 | Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 1,163.5 мянган төгрөгийг хүүхдийн үдийн цайны зардалд гүйлгэн зарцуулсан байна. | 1 | 1,163.5 | | | | | 1 | 1,163.5 | | | | |
| 3 | Тайлант хугацаанд 1,029.2 мянган төгрөгийн шатахууны орлого зарлагын нягтлан бодогч хийсэн боловч нярвын тайлан гаргаж ирүүлээгүй байна. | 1 | 1,029.2 | | | | | 1 | 1,029.2 | | | | |
| | **Нийт дүн** | **3** | **8,292.1** | **1** | **6,099.4** | **0** | **0** | **2** | **2,192.7** | **0** | **0** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс байгууллагын батлагдсан төсвийг улирал бүр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүтэн жилээр мэдээлэх 825696.7 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, 699459.6 мянган төгрөгийн 85 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |

oOo